

АГУУЛГА

<u>БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА</u>	1-6
<u>1.1 Төслийн ерөнхий мэдээлэл</u>	3
<u>1.2 Төслийн талбайн байршил</u>	3-4
<u>БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</u>	6
<u>2.1 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:</u>	6
<u>2.2 Байгаль орчны төлөв байдал:</u>	Error! Bookmark not defined.8
<u>БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</u>	9-10
<u>БҮЛЭГ IV. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</u>	11
<u>БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</u>	12-14
<u>БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</u>	Error! Bookmark not defined.14-15
<u>БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ</u>	15
<u>БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</u>	15
<u>БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</u>	15
<u>БҮЛЭГ X. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</u>	15-16
<u>БҮЛЭГ XI. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</u>	16-18
<u>БҮЛЭГ XII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН</u>	ТӨЛӨВЛӨГӨӨ 18-20
<u>БҮЛЭГ XIII. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</u>	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн солбицол.....	4
Хүснэгт 2. Нөлөөллийн шинж чанар, төрөл.....	9
Хүснэгт 3. Нөлөөллийн шалгуур.....	9-10
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийн зэрэглэл тогтоох матриц, өнгөний код.....	10
Хүснэгт 5. Эерэг нөлөөллийн зэрэглэл тогтоох матриц, өнгөний код	10
Хүснэгт 6. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгтгэл.....	11
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12-14
Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	14-15
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15-16
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	16-18
Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18-19
Хүснэгт 12. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1_Төслийн байршил.....	3
Зураг 2. Үйлдвэрийн талбайн ерөнхий зураг.....	5
Зураг 3. Баяжуулах үйлдвэр.....	5
Зураг 4.Коксын үйлдвэр	5
Зураг 5. Үйлдвэр дэх ШТС.....	5
Зураг 6. Ажилчдын байр.....	5
Зураг 7. Үйлдвэрийн харагдах байдал.....	6


БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

“Мөнх Тэнүүн Оргил” ХХК нь 2023 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Өмнөговь аймгийн Баян Овоо сумын 1-р багийн нутагт 20 га талбайд “Кокс-химийн үйлдвэр” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Уг үйлдвэрийг 2008 онд “Таван толгой транс” ХХК барьж ашиглалтад оруулсан бөгөөд тогтвортой ажиллаж чадалгүй зогссон тул 2023 оноос “Мөнх Тэнүүн Оргил” ХХК нь эзэмших болсноор нүүрс угаах үйлдвэр болон коксын зууханд ахин нэмэлт хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэлийг шат дараатайгаар хийж, төслийн шинэчилсэн тооцоогоор Кокс-Химийн үйлдвэр нь жилд 550.0 мянган тонн нүүрсийг баяжуулж 304.5 мянган тонн угаасан нүүрс, 79.7 мян.тн эрчим хүчний нүүрс гаргаж, 304.5 мян.тн угаасан нүүрснээс 232.9 мянган тонн кокс, 12.2 тн пек үйлдвэрлэж экспортод гаргахаар төлөвлөж байна.

1.2 Төслийн талбайн байршил

Төслийн байршил нь Улаанбаатар хотоос Улаанбаатар хотоос 620 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос 130 км, Баян-овоо сумын төвөөс баруун хойш 40 км, Гашуун сухайт боомтоос 205 км-т Зайрмагтай хөндийд байрлана. “Кокс, коксжих нүүрсний үйлдвэр” нь коксын 1,2-р батарей, кокс хөргөх цамхаг, шатдаг хийн яндан, шатдаг хийн цэвэрлэх байгууламж, дизель станцын байр, баяжуулах үйлдвэр, 1,2-р бутлуур, туузан дамжуургууд, баяжуулах нүүрсний талбай, эрчим хүчний нүүрсний талбай, шатахуун түгээх станц, ажилчдын байр, коксжих нүүрсний талбай, коксын талбай, давирхай болон хөргөлтийн усан сан зэргээс бүрдэнэ.



Зураг 1. Төслийн байршил

Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбицол

№	X	Y
1	43.33752	106.0465
2	43.33906	106.0465
3	43.33908	106.0503
4	43.33802	106.0503
5	43.33804	106.0515
6	43.33807	106.0531
7	43.33807	106.0539
8	43.33808	106.056
9	43.33536	106.056
10	43.33535	106.0514
11	43.33575	106.0513
12	43.33575	106.0493
13	43.33607	106.0493
14	43.33607	106.0497
15	43.33753	106.0497

1.3 Хүчин чадал

“Кокс химийн үйлдвэр” нь жилд 550.0 мянган тонн нүүрсийг баяжуулж, 304.5 304.5 мянган тонн угаасан нүүрс, 79.7 мян.тн эрчим хүчний нүүрс гаргаж, 304.5 мян.тн угаасан нүүрснээс 232.9 мянган тонн кокс, 12.2 тн пек үйлдвэрлэж экспортод гаргах хүчин чадалтай. Төслийн талбайд төслийн удирдлагын хэсэгт 32 ажилтан, баяжуулах үйлдвэрийн хэсэгт 60 ажилтан, коксын үйлдвэрийн хэсэгт 50 ажилтан нийт ажиллах хүч 144 хүний бүрэлдэхүүнтэй, 2 ээлжээр ажиллахаар төлөвлөж байна. Төслийг хэрэгжүүлэх үндсэн мэргэжилтнүүдийг БНХАУ аас гэрээтээр авч ажиллуулж, Монгол ажилчдаа дадлагажуулан сургаж ажиллуулна. Нарийн мэргэжил шаардахгүй ажлын байруудад орон нутгийн иргэдийг сурган авч ажиллуулахаар төлөвлөж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу уртын ээлжээр ажиллах ажилчдыг 14:14 хоногоор ээлжээр ажиллуулахаар орон тоог тооцсон.


1.4 Төслийн барилга байгууламжууд

“Мөнх Тэнүүн Оргил” ХХК-ийн кокс, химийн үйлдвэр нь барилга байгууламжийн дараах хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

- Анхдагч нүүрс буулгах талбай /11/
- Баяжуулах үйлдвэр /7, 8, 9, 10,19, 18/
- Коксжих нүүрс буулгах талбай /15,12, 6/
- Коксын үйлдвэр/1.1,1.2, 2.1, 2.2, 3.1, 3.2, 4, 5, 6, 17/
- Коксын талбай /16/

- Шатахуун түгээх станц /13/, ажилчдын байр /14/ зэргээс бүрдэнэ.



Зураг 2. Үйлдвэрийн талбайн ерөнхий зураг



Зураг 3. Баяжуулах үйлдвэр



Зураг 4. Коксын үйлдвэр



Зураг 5. Үйлдвэр дэх ШТС



Зураг 6. Ажилчдын байр



Зураг 7. Үйлдвэрийн харагдах байдал

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн дэд бүтэц

Нийгэм эдийн засгийн төлөв байдал: Тус аймагт 2023 оны жилийн эцсийн байдлаар 25,336 өрхийн 76,153 хүн оршин сууж байна. Өмнөговь аймгийн өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар, хүн амын тоо өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өссөн байна. 2023 оны жилийн эцсийн малын тооллогоор 6250 малтай өрх, 9416 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 690 малчин, 330 малтай өрхөөр буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд 2042 мян.тол мал тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 595.33 мян.тол буюу 29.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2023 оны байдлаар нийт мал сүргийн 4.5 хувийг адуун сүрэг, 1.3 хувийг үхэр сүрэг, 7.7 хувийг тэмээн сүрэг, 26.8 хувийг хонин сүрэг, 59.7 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Баян-Овоо сум. Баян-Овоо суманд 2023 оны жилийн эцсийн байдлаар 573 өрхийн 1650 хүн оршин сууж байна. Тус сумын өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар, хүн амын тоо өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурсан байна. 2023 оны жилийн эцсийн малын тооллогоор 330 малтай өрх, 521 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 25 малчин, 10 малтай өрхөөр багассан үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд 118.19 мян.тол мал тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 61 мян.тол буюу 51.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2023 оны байдлаар нийт мал сүргийн 5.4 хувийг адуун сүрэг, 1.2 хувийг үхэр сүрэг, 6.3 хувийг тэмээн сүрэг, 29.7 хувийг хонин сүрэг, 57.4 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

1-р баг. Могойт багт 2023 оны жилийн эцсийн байдлаар 191 өрхийн 532 хүн оршин сууж байна. Тус багийн өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар, хүн амын тоо өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурсан байна. 2023 оны жилийн эцсийн малын тооллогоор 100 малтай өрх, 147 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад

21 малчин, 10 малтай өрхөөр буурсан үзүүлэлттэй байна. Багийн хэмжээнд 37.07 мян.тол мал тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 20.04 мян.тол буюу 54.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2023 оны байдлаар нийт мал сүргийн 7.2 хувийг адуун сүрэг, 0.9 хувийг үхэр сүрэг, 4.3 хувийг тэмээн сүрэг, 37.8 хувийг хонин сүрэг, 49.8 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Цахилгаан хангамж: Үйлдвэрийн бүс нь төвийн цахилгаан системтэй холбогдоогүй бөгөөд үйлдвэрлэл болон ахуйн дотоод цахилгаан хангамжийг дизель генератор ашиглан хангадаг. Тус бүр нь 150кВт хүчин чадалтай 4 ширхэг дизель генератортой бөгөөд 3 генератор нь төслийн цахилгаан хэрэглээг хангаж, 1 генератор байнгын бэлэн байдалд зогсож байна.

Холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж: Кокс-химийн үйлдвэрийн бүсэд ажил үүргийн зориулалтаар богино долгионы радио станц ашиглана. Ажилчдын оффис лаборатори болон хувийн зориулалтаар интернэт холболтыг утасгүй үүрэн телефоны оператор компанийн үйлчилгээг ашиглаж хангаж байна.

2.2 Байгаль орчны төлөв байдал

Физик газарзүйн нөхцөл. Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар авч үзвэл говийн их мужид хамаарагдана. Говийн их муж нь манай орны өмнөд хагасыг голчлон эзэлж оршихдоо хойд талдаа Монгол дорнод тал, Хангай, Хэнтийн их мужтай хил нийлж баруун хойшоо улсын хил хүртэл үргэлжлээд Монгол Алтайн уулархаг их мужуудаас их буюу 545900 км² талбайг хамарна.

Цаг уур, уур амьсгал. Төслийн талбайн орчим нь уур амьсгалын хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. Уур амьсгалын үндсэн нөхцөл нь хоног, сар, жилийн агаарын температурын агууриг их, агаарын чийгшил бага, хур тунадасны хуваарилалт жигд бус, зундаа их халж, өвөлдөө их хүйтрэх зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдоно. Төлөв байдлын үнэлгээнээс үзэхэд төслийн төлөвлөлтөд хүчтэй нөлөө үзүүлэх, гамшиг үүсгэж болзошгүй уур амьсгалын үзүүлэлт байхгүй байна.

Геологи, геоморфологи. Судалгааны талбайн хэмжээнд гол, сайрын аллювиаль гаралтай хурдас хуримтлалын гадаргуу тархсан. Хамгийн өргөн тархалттай гадаргуугийн хэлбэр юм. Уулын хажуу, Мезозойн хотгоруудын хэмжээгээр, доош шилжиж буй голын хөндий зэрэгт илэрнэ. Хуримтлалын гадаргууг хотгор, хавтгай, уулс доторх хотгорын дундах налуу гүвээрхэг хонхорын, Миоцены хавтгай хотгорын аллювиаль сул барьцалдсан аллювиаль-пролювиаль, тэгшрэлийн налуу хажуугийн сул долгиолог, нуурын, нуурын-аллювиаль, доворхог хярын элювийн, эоловийн тэгшрэлийн гэх зэрэг олон төрөлд хуваагддаг. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын хэмжээнд геологийн тогтоц нь боржингийн массив, Мезозойн сүүл үе, Мезозойн эхэн үе, Палезойн сүүл ба Мезозойн эхэн үе, Палезойн дунд үе, Ценозойн эриний хэв шинж бүхий хурдас хуримлагдан тогтсон байна. Эдгээрээс ценозойн эрний болон мезозойн сүүл үеийн хэв шинж бүхий хурдас хуримтлал бүхий тогтоц тус сумын хэмжээнд голчлон тархсан байна. Үүнээс гадна тус сумын нутгийн зүүн өмнөд хэсэг, өмнөд хэсэг, төв хэсгийн зарим хэсгээр боржингийн хэд хэдэн массив байдаг байна. Мөнх тэнүүн оргил ХХК-ний үйл ажиллагаа явуулах төслийн талбайн хувьд Ценозойн эрний хэв шинжтэй хурдас хуримтлагдсан байна.

Гадаргын ус болон газрын доорх ус. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт байрлах “Мөнх тэнүүн оргил” ХХК-ийн “Кокс-химийн нүүрсний үйлдвэр” төсөл нь Галба

Өөш Долоодын говийн савд хамаарах ба тус сав газрын талбай нь геологийн нийлмэл тогтоцтой, янз бүрийн нас, найрлагын гүний биетүүдээр зүсэгдсэн, хагарлын системүүдээр хэрчигдсэн блоклог бүтцийг бий болгосон зэрэг болно. Төслийн үйл ажиллагаанд ашигладаг худгийн уснаас болон төслийн талбайн ойролцоо орших худгийн уснаас дээж авч усны химийн шинжилгээг “Грийн лаб” хөрс, усны лабораторид шинжлүүлсэн болно. Дээжлэлт хийсэн 2 худгийн усны шинжилсэн химийн үзүүлэлтүүдийг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулахад үйлдвэрийн талбайн худгийн усанд дахь хлоридын ион нь давсан үзүүлэлттэй гарсан байна.

Хөрсөн бүрхэвч. Төсөл хэрэгжих талбай орчмын бүс нутаг нь цөлжүү хээр бүхий экосистемтэй, дтд 1315-1320 м үнэмлэхүй өндөртэй талархаг тэгш хөндий бүхий газарт байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь Бор хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг Бор хөрсний хэв шинжид багтах сайргархаг болон элсэрхэг төрлийн хөрснүүд тархсан байна. Эдгээрээс сайргархаг Бор төрлийн хөрс талбайн 51%, элсэрхэг карбонаттай Бор хөрс 25%, сайрын хөрс 3.5% орчимд зонхилон тархсан байна.

Ургамлын аймаг. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог-т хамаарагддаг. Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог нь нийт 480 зүйлтэй ба жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн бөгөөд зөвхөн энд ургадаг 9 зүйл тохиолдоно. Одой хайлас (*Ulmus pumila*), Монгол бүйлэс (*Amygdalus mongolica*), Нангиад зээргэнэ (*Ephedra sinica*), Төвд харгана (*Caragana tibetica*), Федианы аргамжинцэцэг (*Cistanche feddiana*), Говийн хялгана (*Stipa gobica*), Сайрын хялгана (*Stipa glauca*), Хөмүүл (*Allium mongolicum*), Таана (*Allium polyrhizum*), Сибирь шорной (*Atriplex sibirica*), Эрлийз лууль (*Chenopodium hybridum*), Орог тэсэг (*Krascheninnikovia ceratoides*), Монгол хамхуул (*Corispermum mongolicum*), Сибирь хармаг (*Nitraria sibirica*), Ёслиг мананхамхаг (*Bassia dasyphylla*), Дэлхээ тогторгоно (*Kochia prostrata*), Каспийн шарбударгана (*Kalidium gracile*), Паульсын бударгана (*Salsola paulsenii*), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica*), Толгодын бударгана (*Salsola collina*), Монгол Потанин (*Potaninia mongolica*), Говийн бэрмэг (*Limonium gobicum*), Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia*), Потанины хотир (*Zygophyllum potaninii*), Монгол ямаалж (*Tragus mongolicum*), Говийн тоост (*Brachanthemum gobicum*), Грубовын ортууз (*Oxytropis grubovii*), Цөлийн тайр (*Gypsophila desertorum*), Монгол шарилж (*Artemisia mongolorum*), Монгол чоногоно (*Jurinea mongolica*), Монгол шардалан (*Tugarinovia mongolica*), Төлөгчдүү боролз (*Ajania achilleoides*) зэрэг болно.

Амьтны аймаг. Төсөл хэрэгжиж буй Зайрмагтай хөндий орчим нь Таван толгойн бүлэг уурхайгаас Гашуун сухайт улсын хилийн боомт чиглэлийн нүүрс тээврийн авто болон төмөр зам дайран өнгөрөх хэсэгт байрлах бөгөөд амьдрах орчны хувьд бүхэлдээ цөлөрхөг хээрийн бүсэд байршина. Энэ бүс нутагт хөхтөн амьтны 30 гаруй зүйл тохиолдох боломжтой бөгөөд 70 орчим хувь нь мэрэгчид болно. Ховор амьтдаас аргаль хонь, янгир ямаа, хар сүүлт зээр, цагаан зээр, хулан адуу тохиолдох боломжтой. Шувуудаас монгол оронд бүртгэгдээд буй 500 гаруй зүйл шувуудаас 200 гаруй нь хавар, намрын үедээ дайран өнгөрөх бол 30 гаруй зүйл шувуу суурин тохиолдоно. Эдгээрийн дотор ховор шувуудаас Монгол хулан жороо жилийн турш тохиолддог. Мөлхөгчдөөс энэ бүс нутагт 2 салбар баг, 5 овог, 7 төрөлд хамаарах 7 зүйлийн мөлхөгчид идээшин амьдарч байна. Задгай усны эх үүсвэргүй, гол, нуурын сав газраас зайд орших тул хоёр нутагт амьтад (мэлхий) тархаагүй болно.

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлсэн байна.

3.1 Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ

3.1.1 Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд

Болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ юуны түрүүнд нөлөөллийн чиглэл, шинж чанарыг тооцно. Нөлөөллийн шинж чанар, төрлийг доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт 2. Нөлөөллийн шинж чанар, төрөл

Шинж чанар, төрөл	Тодорхойлолт
Эерэг	Суурь нөхцөлийг сайжруулж, эерэг өөрчлөлт бий болгох нөлөөлөл
Сөрөг	Суурь нөхцөлийг дордуулж, таагүй шинэ хүчин зүйл бий болгох нөлөөлөл
Шууд	Төслийн төлөвлөсөн үйл ажиллагаа болон байгаль орчин/хүлээн авагчид хоорондын шууд харилцаанаас үүссэн нөлөөлөл
Дам	Төслийн үр дагавраар бий болох бусад үйл ажиллагаанаас үүсэх нөлөөлөл

Нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлсон хүлээн авагчид буюу нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийн зэрэглэлийг үнэлгээний шалгуурын дагуу тогтоож үнэлэн, болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, төслийн үр шимийг дээшлүүлэх арга хэмжээ боловсруулдаг.

Хүснэгт 3. Нөлөөллийн шалгуур

Нөлөөллийн шалгуур	
Цар хүрээ	Төслийн талбай – бүтээн байгуулалтын талбайн хилээр хязгаарлагдах нөлөөлөл Орон нутгийн – бүтээн байгуулалтын ойролцоох хот суурин, орон нутгийг хамрах нөлөөлөл Бүсийн – бүс нутгийн хэмжээнд чухал ач холбогдолтой байгалийн нөөцийг хамрах нөлөөлөл буюу засаг захиргааны хил, амьдрах орчны төрөл/экосистемээр бүс нутгийн хэмжээнд үүссэн гэж тодорхойлсон нөлөөлөл Үндэсний – улсын хэмжээнд чухал ач холбогдолтой байгалийн нөөцийг хамрах нөлөөлөл буюу улсын хэмжээнд чухал ач холбогдолтой/макро эдийн засгийн түвшинд үр дагавар авчрах нөлөөлөл
Хугацаа	Түр хугацааны – богино буюу түр хугацаанд үе үе/хааяа тохиолдох нөлөөлөл Богино хугацааны – зөвхөн барилга угсралтын шатанд тохиолдох нөлөөлөл Урт хугацааны – төслийн үйл ажиллагаа зогсохтой зэрэгцэн зогсох төслийн хугацааны туршид үргэлжлэх нөлөөлөл Хугацаагүй – өртсөн хүлээн авагч, нөөцөд байнгын өөрчлөлт авчрах, төслийн дараа ч үргэлжлэх нөлөөлөл (амьдрах орчныг устгах гэх мэт)
Эрчим	БИОФИЗИКИЙН ОРЧИН: Нөлөөллийн эрчмийг биологийн олон янз байдлын хүлээн авагчийн (амьдрах орчин, зүйл, бүлгэмдэл гэх мэт) эмзэг байдалтай холбогдуулан авч үздэг. Маш бага – Байгаль орчинд нөлөөлөл илрэхгүй. Бага – Экосистемийн гүйцэтгэх үүрэг, үйл явцад нөлөөлөхгүй нөлөөлөл.

	Дунд – Экосистемд өөрчлөлт оруулах ба түүний гүйцэтгэх үүрэг, үйл явц өөрчлөгдсөн байдлаараа үргэлжилнэ. Их – Экосистемийн гүйцэтгэх үүрэг, үйл явц түр болон бүр зогсох хэмжээнд хүргэх нөлөөлөл. Нөлөөллийн үнэлгээнд дотоодын болон олон улсын стандартуудыг ашиглана. Судалгаагаар нөлөөллийн хэмжээг тооцох ба үндэслэлээ гаргана. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН: Төслийн нөлөөллөөр бий болсон өөрчлөлтөд дасан зохицох, Төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийн чадварыг авч үзнэ. Маш бага – Иргэдийн амьдралд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй. Бага – Иргэд амархан дасан зохицож, нөлөөллийн өмнө байсан амьдралын түвшнээ хадгална. Дунд – Иргэдэд дасан зохицох нь зарим талаар бэрхшээлтэй ба тусламж дэмжлэг авснаар нөлөөллийн өмнө байсан амьдралын түвшнээ хадгална. Их – Иргэд өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийн өмнө байсан амьдралын түвшнээ хадгалах чадваргүй байна.
Цар хүрээ	
Маш бага	Үнэлгээнд хамруулсан тодорхой нөхцөлд мэдэгдэхүйц өөрчлөлт үүсэхгүй.
Бага	Үнэлгээнд хамруулсан тодорхой нөхцөлд маш бага өөрчлөлт үүснэ.
Дунд	Үнэлгээнд хамруулсан тодорхой нөхцөлд үүссэн өөрчлөлтийн улмаас түр болон байнгын өөрчлөлт гарна.
Их	Үнэлгээнд хамруулсан тодорхой нөхцөлд урт хугацаанд байнгын үндсэн өөрчлөлт орох ба ихэнхдээ байгаль орчинд өргөн хүрээнд тархана. Суурь нөхцөлд хүргэн нөхөн сэргээхэд ихээхэн хүчин зүтгэл орно. Улсын стандартаас хэтэрнэ.
Магадлал	
Магадгүй	Нөлөөлөл үүсэж магадгүй
Болзошгүй	Ихэнх нөхцөлд нөлөөлөл үүсэж болзошгүй
Боломжтой	Нөлөөлөл үүснэ

Дээр дурдсан нөлөөллийн шинж чанаруудыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тодорхойлсны дараа нөлөөллийн зэрэглэлийг матрицын аргын дагуу үнэлнэ.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийн зэрэглэл тогтоох матриц, өнгөний код

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ЗЭРЭГЛЭЛ			
Цар хүрээ	Магадлал		
	Магадгүй	Болзошгүй	Болзошгүй
Маш бага	МАШ БАГА	МАШ БАГА	БАГА
Бага	МАШ БАГА	БАГА	БАГА
Дунд	БАГА	ДУНД	ДУНД
Их	ДУНД	ИХ	ИХ

Хүснэгт 5. Эерэг нөлөөллийн зэрэглэл тогтоох матриц, өнгөний код

ЭЭРЭГ НӨЛӨӨЛЛИЙН ЗЭРЭГЛЭЛ			
Цар хүрээ	Магадлал		
	Магадгүй	Болзошгүй	Болзошгүй
Маш бага	МАШ БАГА	МАШ БАГА	БАГА
Бага	МАШ БАГА	БАГА	БАГА
Дунд	БАГА	ДУНД	ДУНД
Их	ДУНД	ИХ	ИХ

БҮЛЭГ IV. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

"Мөнх тэнүүн оргил" ХХК-ийн 2025 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино.

Хүснэгт 6. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгтгэл

№	Төлөвлөгөөний төрөл	Зардлын дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1240.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2000.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700.0
5	Осол, эрсдэл менежментийн төлөвлөгөө	1250.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	880.0
Төлөвлөгөөний нийт зардал		6070.0

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон ЗГ-ын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн үнэлгээний журам, А/117-р ийн 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болгон боловсруулсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэлт, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ажил хийгдэхгүй болно.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **6,070,000** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн байна. “Ecotusoon” ХХК нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгүүлсэн байна. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8	9
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Агаарын чанар	Төслийн зөвшөөрөлтэй талбайн хилийн дагуу салхинаас хамгаалах хашаа бий болгох	Төслийн талбайд	Жилд	Тухай бүр	300.0	300.0	IV-р улиралд багтаан	MNS3113:1981 “Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага”
2		Коксын зуухны янданд 3 үе шат бүхий шүүлтүүр хийх	Төслийн талбайд	Жилд	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	MNS3384:1982 “Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ” MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах

									бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”
4	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Худаг уст цэгийг байр барилгыг засаж сайжруулах, тэмдэгжүүлэх	Төслийн талбайд	-	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт /Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай/, MNS 13.06050 Усны чанарын стандарт, MNS 3342:1982 Газар доорх усыг бохирдлоос хамгаалах
5		Төслийн талбайн гадна байрлах 1 уст цэгийг хашаажуулж хамгаалах	Төслийн талбайд	-	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
6		Усны дүгнэлт гаргуулж гэрээ байгуулах	Төслийн талбайд	-	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
8	Хөрсөн бүрхэвч	Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх	Төслийн талбайд	Жилд	1 удаа	200.0	200.0	IV-р улиралд багтаан	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
9		Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих, сэргээн засварлаж байх	Төслийн талбайд	-	Тухай бүр	200.0	200.0	IV-р улиралд багтаан	

10		Нүүрс буулгах талбайг хатуу хучилттай болгох	Төслийн талбайд	-	Хуваарийн дагуу	540.0	540.0	IV-р улиралд багтаан	Техникийн шаардлага MNS 5915:2008, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах Техникийн шаардлага MNS 5916:2008
Нийт							1240.0		

БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй нөхөн сэргээлт хийсэн байх үүрэгтэй.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө									
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих	Төслийн талбайд	ш	500	1000.0	1000.0	IV-р улиралд багтаан	MNS5917-2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS5918-2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
2		Өмнө жилийн талбайн ногоон байгууламжийн тордох, услах, арчлах	Төслийн талбайд	Жилд	1	1000.0	1000.0	5,10-р сард	

									Монгол улсын MNS 6253-252011 дагуу мод сөөг тарих, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйл Байгаль орчиныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл
Нийт						2000.0			

БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд Төслийн үйл ажиллагаанд болон БОМТ төлөвлөж өгөөгүй болно.

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд Төслийн үйл ажиллагаанд болон БОМТ төлөвлөж өгөөгүй болно.

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажлыг төлөвлөгөөгүй болно.

БҮЛЭГ X. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Монгол улсын хууль болон стандартуудыг баримтална. Төслөөс энэхүү үүргүүдээ биелүүлэхдээ эцсийн байдлаар үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах үүднээс хийсэн менежментийн сонголтыг үнэлж дүгнэх арга барилыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө									
1	Ахуйн	Хог хаягдлыг түр цэгт хадгалах, ангилан ялгаж тэмдэгжүүлсэн байх	Төслийн талбайд	-	Тухай бүрт	200.0	200.0	IV-р улиралд багтаан	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р Зүйл, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
2		Ангилан ялгах хогийн сав байршуулж тэмдэгжүүлэх	Бүх байршилд	-	Тухай бүрт	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
3		Хог хаягдлын талбайн суурийг цементлэх	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	500.0	500.0	IV-р улиралд багтаан	
4		Хог хаягдлын гэрээг сум орон нутагтай байгуулах, тайлан мэдээг цаг хугацаанд хүргүүлэх	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
Нийт							700.0		

БҮЛЭГ XI. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Мөнх тэнүүн оргил” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах

үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр									
1	Ус	Усны хими,микробиологи, хүнд металлын шинжилгээг өгөх	Гүний худагт	жилд	2 удаа	300.0	300.0	IV-р улиралд багтаан	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000
2		Бохир усны шинжилгээ	Хаягдал уснаас	жилд	2 удаа	200.0	200.0	IV-р улиралд багтаан	
3	Хөрс	Хөрсний шинжилгээ /Хөрсний чанар агрохими физикийн ерөнхий үзүүлэлт, хүнд металл бохирдол/	Хяналтын 3 цэгт	жилд	1удаа	280.0	280.0	IV-р улиралд багтаан	Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт , MNS 0900 : 2005 Ундны ус.
4	Агаар	Агаарын тоос, дуу чимээний бохирдол	Хяналтын 6 цэгт	жилд	1удаа	100.0	100.0	IV-р улиралд багтаан	Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS
5	Үйлдвэрт ашиглагдах түүхий эдээс цацрагийн шинжилгээ тогтмол авах	Түүхий эд буулгах талбай	Түүхий эд татах бүрт	жилд	Тухай бүрт	-	-	IV-р улиралд багтаан	

									3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад MNS 4585:2016 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
Нийт							880.0		

БҮЛЭГ XII. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт 11. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
---	---------------------	---	-------------------------------	--------------	------------	-------------------------	----------------------	------------------------------	---------------------------------

сөрөг нөлөөллүүд									
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө									
1	Болзошгүй гэнэтийн аюул осол, байгалийн давагдашгүй хүчин зүйл Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болох нөлөөлөл	Ажилчид газар хөдлөлт болон онцгой байдлын үед цугларах талбайг тэмдэгжүүлэх	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	ОБЕГ-ын даргын 2016 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах заавар”
2		Суурь дуут дохионы систем суурилуулах	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	500.0	500.0	IV-р улиралд багтаан	
3		Аянга зайлуулагч байршуулах	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
4		Үерийн далан суваг байгуулах	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	500.0	500.0	IV-р улиралд багтаан	
5		Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ажлын байрны нөхцөл бүрээр хангах	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	250.0	250.0	IV-р улиралд багтаан	
6		Гал унтраах хэрэгслийг байршил, MNS 5560:2025 стандартын дагуу байршуулах	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
7		Гамшиг болон аюул ослын үед авах арга хэмжээний сургалтыг онолын болон практик сургалтын зохион байгуулах бүх ажилчдад	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
8		Цахилгааны газардуулагын ажлыг хийх	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	

9		Тээврийн хэрэгслийг даатгалд хамруулах, үзлэгт оруулах, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд шат дараалалтай хамруулах	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
Нийт							1250.0		

БҮЛЭГ XIII. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

“Мөнх тэнүүн оргил” ХХК -ийн амралтын газрын төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **6,070,000 мян.төг** зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 12. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Дүүргийн ИНХ	Проектор танилцуулга	БОМТ-ний 2025 оны тайлангийн танилцуулга	Жилд	-	БОМТ хариуцсан ажилтан	ИНХурлын танхим, төсөл хэрэгжүүлж буй газар
БОУАӨЯам ХБОБНГазарт	Проектор танилцуулга	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2025 онд	-	БОМТ хариуцсан ажилтан	
Нийт				-		